ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 10 сарын 16 өдөр Дугаар 133 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Радио долгионы тухай хуулийн 5^1 дүгээр зүйлийн 5^1.1.8 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын 2025 оны А/281 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсгийн 2026 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн дүгнэлтийн дагуу тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаагүй “Өвөр даваат” ХХК-ийн Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх 13400104 дүгээр тусгай зөвшөөрөл болон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 23400071 дүгээр тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болсонд тооцсугай.

2.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хуулийн этгээдийн харьяалах татварын албанд мэдэгдэх, холбогдох өөрчлөлтийг мэдээллийн нэгдсэн санд оруулах арга хэмжээ авахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

3.Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасан хугацаанд шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР